



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 10 дугаар сарын 07
№38 (1334)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

639.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 90	3771
------	---	-----------	------

640.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 127	3772
------	---	------------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

641.	Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай	Дугаар 39	3773
------	--	-----------	------

642.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 40	3798
------	-----------------------------	-----------	------

643.	Журам батлах тухай	Дугаар 42	3807
------	--------------------	-----------	------



504.	ᠮᠣᠩᠭ᠎ᠠ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ	ᠳᠠᠨᠭᠡᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨ
505.	ᠮᠣᠩᠭ᠎ᠠ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ	ᠳᠠᠨᠭᠡᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨ
509.	ᠮᠣᠩᠭ᠎ᠠ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ	ᠳᠠᠨᠭᠡᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨ
500.	ᠮᠣᠩᠭ᠎ᠠ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ	ᠳᠠᠨᠭᠡᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨ
500.	ᠮᠣᠩᠭ᠎ᠠ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ ᠲᠤᠨᠭᠡᠨᠢ	ᠳᠠᠨᠭᠡᠨᠢ	ᠪᠠᠭᠠᠨ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2024 оны 06 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржийн Баярхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дааданхүүгийн Батбаатарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ

Mongolian State Agency for External Relations

Урьдчилсан гэрээний үндсэн дээр 2024 оны 06 сарын 20-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржийн Баярхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дааданхүүгийн Батбаатарыг томилсугай.

Урьдчилсан гэрээний үндсэн дээр

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2024 оны 08 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 127

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвшингийн Бадралыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямаагийн Энхболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

Mongolian State Information Agency

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ
ᠶ᠋ᠢᠨᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 24.1.5, 38.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн”-ийг 1 дүгээр хавсралт, “Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн”-ийг 2 дугаар хавсралт, “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”-ийг 3 дугаар хавсралт, “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэ тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын дагуу дундаж хэмжээгээр тооцсон нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг энэ оноос эхлэн хянан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т тус тус даалгасугай.

3.Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан хүн амын тоо, газар зүйн байршил, сургууль, цэцэрлэгийн ачаалал зэргийг харгалзан холбогдох суурь судалгаа, шинжилгээг хийсний үндсэн дээр сургууль, цэцэрлэгийн бүтцийг цаашид оновчтой болгох, анги дүүргэлтийг тогтоосон нормын дагуу тооцож, төсвийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан даалгасугай.

4.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагад 2024 онд хуваарилах нэг суралцагчид ногдох хувьсах зардлын санхүүжилтийг өмнөх оны түвшингээс бууруулахгүй байхаар тооцож, батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан даалгасугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 91 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ЭНХ-АМГАЛАН



Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

(жилийн дүнгээр, мянган төгрөгөөр)

№	Бүрэлдэхүүн	Хувьсах зардлын хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр
А. Суурь хувьсах зардал		1,485.0	-
1.	Багшийн үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 45.7 хувь	Улсын төсөв 73.7 хувь, үүсгэн байгуулагч 26.3 хувь
2.	Багшийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 13 хувь	Улсын төсөв
3.	Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал	Нийт хувьсах зардлын 1.3 хувь	Улсын төсөв
Б. Бусад хувьсах зардал		990.0	-
1.	Захиргаа, аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар тооцсон үндсэн цалин, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 26.9 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
2.	Захиргаа, аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар тооцсон нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 10.4 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
3.	Цэцэрлэгийн үйл ажиллагааны урсгал болон ариутгал, цэвэрлэгээний зардал, хүүхэд хамгааллын зардал	Нийт хувьсах зардлын 1.5 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв



4.	Багшийн хөгжлийн зардал	Нийт хувьсах зардлын 0.3 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
5.	Эрүүл мэндийн үйлчилгээний зардал	Нийт хувьсах зардлын 0.3 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
6.	Цахим хэрэглээний зардал	Нийт хувьсах зардлын 0.2 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
В. Нөхөн хангалтын хувьсах зардал		-	-
1.	Хүүхдийн тоглоом, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал	Нийт хувьсах зардлын 0.4 хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
Г.Нийт хувьсах зардал		100 хувь	
1.	Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ	48 хувь	
2.	Үүсгэн байгуулагчийн хариуцах зардлын хувь хэмжээ	52 хувь	

----o0o----

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр
сарын 25-ны өдрийн 39 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН
ДУНДАЖ ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН**

А.Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний
бүрэлдэхүүн

(жилийн дүнгээр, мянган төгрөг)

№	Бүрэлдэхүүн	Хувьсах зардлын хэмжээ										Санхүүжүүлэх эх үүсвэр		
		I анги	II анги	III анги	IV анги	V анги	VI анги	VII анги	VIII анги	IX анги	X анги		XI анги	XII анги
	А.Суурь хувьсах зардал	867.0	873.0	882.0	953.0	982.0	1,181.0	1,240.0	1,275.0	1,300.0	1,256.0	1,317.0	1,337.0	
	Багшийн үндсэн цалин, ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 52.2 хувь												
1.	Багшийн нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 19.3 хувь										Улсын төсөв		
3.	Хичээл, сургалтын ажиллагааны зардал	Нийт хувьсах зардлын 1.2 хувь												
	Б.Бусад хувьсах зардал	326.0	328.0	331.0	358.0	369.0	444.0	466.0	479.0	488.0	472.0	495.0	502.0	-



		Үүсгэн байгуулагчийн төсөв
Захиргаа, аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар тооцсон үндсэн цалин, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 13.3 хувь	
1. Захиргаа, аж ахуйн ажилтны нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 5.2 хувь	
2. Сургуулийн үйл ажиллагааны урсгал зардал	Нийт хувьсах зардлын 1.4 хувь	
3. Балшийн хөгжлийн зардал	Нийт хувьсах зардлын 0.9 хүртэлх хувь	
4. Эрүүл мэндийн үйлчилгээний зардал	Нийт хувьсах зардлын 0.3 хувь	
5. Цахим хэрэглээний зардал	Нийт хувьсах зардлын 2.2 хувь	
6. Анги танхимын ариутгал, цэвэрлэгээний зардал	Нийт хувьсах зардлын 0.3 хувь	
7. Танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагааны зардал	Нийт хувьсах зардлын 0.2 хувь	
8. Хүүхэд хамгаалал	Нийт хувьсах зардлын 0.3 хувь	
В. Нөхөн хангалтын хувьсах зардал	-	
1. Тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал	Нийт хувьсах зардлын 3.2-14 хүртэл хувь	Үүсгэн байгуулагчийн төсөв
Г. Нийт хувьсах зардал	100 хувь	
1. Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ	72.7 хувь	
2. Үүсгэн байгуулагчийн хариуцах зардлын хувь хэмжээ	27.3 хувь	

Б.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ, түүний бүрэлдэхүүн

(жилийн дүнгээр, мянган төгрөг)

№	Бүрэлдэхүүн	Хэмжээ	Санхүүжүүлэх эх үүсвэр
A	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ	2029.8	Үүсгэн байгуулагчийн төсөв
1.	Дотуур байрны башийн цалингийн сан, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 20.6 хувь	
2.	Дотуур байрны захиргаа, аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар тооцсон үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Нийт хувьсах зардлын 77 хувь	
3.	Дотуур байрны үйл ажиллагааны зардал	Нийт хувьсах зардлын 2.4 хувь	

Жич: Дотуур байрны багш, захиргаа, аж ахуйн ажилтны үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хуваарилалтыг тогтоолын 2 дугаар хавсралтын суурь болон бусад хувьсах зардалд заасан үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг баримтална.

----000----



Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

**ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НЭГ СУРАЛЦАГЧИД
НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН БАЙРШИЛ, ХҮҮХДИЙН ТООНООС
ХАМААРАН ӨСӨН НЭМЭГДЭХ ИТГЭЛЦҮҮР**

А.Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн байршлаас хамаарах итгэлцүүр:

№	Байгууллага	Нийслэл	Аймгийн төвийн сум	Сум (аймгийн төвөөс 200 км хүртэлх)	Сум (аймгийн төвөөс 201 км-ээс дээш)
1.	Цэцэрлэг	-	1.065	1.087	1.091
2.	Ерөнхий боловсролын сургууль	-	1.065	1.08	1.084

Б.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн тооноос хамаарах итгэлцүүр:

№	Суралцагчийн тоон интервал	Үржүүлэгч итгэлцүүр
1.	1-350	1.53
2.	351-550	1.46
3.	551-900	1.26
4.	901-1500	1.1
5.	1500-аас дээш	1.00

В.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт хөтөлбөрөөс хамаарсан итгэлцүүр:

№	Хөтөлбөрийн нэр	Итгэлцүүр
1.	Математикийн хичээлийн хоцрогдол нөхөх, арилгах, унших чадварыг нэмэгдүүлэх	0.025
2.	Англи хэлний дэмжих хөтөлбөр	0.024
3.	Төрөлжсөн сургалтын хөтөлбөр	1.017

Г.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн тооноос хамаарах итгэлцүүр:



№	Хүүхдийн тоо	Итгэлцүүр
1.	1-25	2.50
2.	26-50	1.75
3.	51-125	1.31
4.	126-175	1.2
5.	176-225	1.15
6.	226-375	1.06
7.	375-аас дээш	1.00

Д.Төрийн болон орон нутгийн өмчийн явуулын бүлгийн хүүхдийн тооноос хамаарах итгэлцүүр:

№	Хүүхдийн тоо	Итгэлцүүр
1.	1-20	1.8
2.	21-35	1.1
3.	36-аас дээш	0.8

Г.Төрийн болон орон нутгийн өмчийн нүүдлийн бүлгийн хүүхдийн тооноос хамаарах итгэлцүүр:

№	Хүүхдийн тоо	Итгэлцүүр
1.	1-20	1.8
2.	21-40	1.3
3.	41-60	1
4.	61-80	0.7
5.	81-ээс дээш	0.5

Е.Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн жилийн нийт сургалтын төлбөрөөс хамаарах итгэлцүүр:

№	Сургалтын төлбөрийн хэмжээ	Итгэлцүүр
1.	Төлбөргүй болон 1,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй	1.0
2.	1,000,001.0-5,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй	0.6
3.	5,000,001.0-10,000,000.0 төгрөг хүртэл төлбөртэй	0.5
4.	10,000,001.0-ээс дээш төгрөгийн төлбөртэй	0.0

----oOo----

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

ХУВЬСАХ ЗАРДАЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНД СУУРИЛАН САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг үндэслэн боловсролын байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлыг тооцох, төсөв хуваарилах, санхүүжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сургуулийн өмнөх (цаашид “цэцэрлэг” гэх) болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээ, нийтийн эзэмшлийн талбайн ариутгал, цэвэрлэгээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд эдгээр зардлыг хувьсах зардлын бүрэлдэхүүнд тооцохгүй.

1.3.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд улсын төсвөөс хувьсах зардлын дундаж хэмжээгээр тооцсон зардлын санхүүжилт олгох үндэслэл нь байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, сургалтын үйл ажиллагааны хамрах хүрээ, тогтвортой байдал, үр дүнг илэрхийлсэн тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл, сургалтын төлбөр тогтоосон шийдвэр, гэрээний гүйцэтгэл, үр дүн, төсвийн төсөлд өгсөн санал байна.

Хоёр.Нэр томьёо

2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“хувьсах зардал” гэж Боловсролын ерөнхий хуулийн 3.1.16-д заасныг;

2.1.2.“цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль” гэж Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 19.1, 20.1-д заасныг;

2.1.3.“сургалтын хөтөлбөр” гэж Боловсролын ерөнхий хуулийн 3.1.13-т заасныг.



Гурав.Хувьсах зардлын дундаж хэмжээ

3.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардлын дундаж хэмжээг үндэслэн олгох санхүүжилт нь сургалтын байгууллагын батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай захиргаа, удирдлагын болон мэргэжлийн чадварлаг багшлах хүний нөөцөөр хангагдах, сургалтын тоног төхөөрөмж, хичээл, практикийн үйл ажиллагааг хэвийн явуулах, боловсролын стандартыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны урсгал зардалд хүрэлцэхүйц байна.

3.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хувьсах зардлын дундаж хэмжээ нь дараах төрөлтэй байна:

3.2.1.суурь хувьсах зардал;

3.2.2.бусад хувьсах зардал.

3.3.Суурь хувьсах зардлын санхүүжилтийг өмчийн хэлбэр харгалзахгүй олгох бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна:

3.3.1.багшийн цалин хөлс, хууль тогтоомжид заасны дагуу түүнд ногдох нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал;

3.3.2.сургалтын хөтөлбөрийн дагуу хэрэглэгдэх сургалтын хэрэглэгдэхүүн, материал, хангамж буюу хичээл сургалтын үйл ажиллагааны зардал.

3.4.Бусад хувьсах зардал нь дараах бүрэлдэхүүнтэй байх бөгөөд төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн санхүүжилтийг үүсгэн байгуулагч, төрийн болон орон нутгийн өмчит сургууль, цэцэрлэгийн санхүүжилтийг төр тус тус хариуцна:

3.4.1.захиргаа, удирдлагын болон багшаас бусад ажилтны цалин хөлс, хууль тогтоомжид заасны дагуу түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал;

3.4.2.сургалтын байгууллагын үйл ажиллагааны урсгал болон анги, танхимын ариутгал, цэвэрлэгээний зардал;

3.4.3.багшийн тасралтгүй хөгжлийг хангахад чиглэсэн сургалтын зардал;

3.4.4.багш, ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон мэргэжлээс шалтгаалах өвчний онцлогийг харгалзан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахтай холбоотой зарим зардал;

3.4.5.хичээл, сургалтын үйл ажиллагааг танхим болон цахим хосолсон, эсхүл зайн хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ, сургалтын удирдлагын мэдээллийн систем, цахим контентын хэрэглээ, программ хангамжийн ашиглалтын зардал;

3.4.6.хичээл, практик, лаборатори, кабинетын сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтад ороогүй, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад багшид шаардлагатай бичгийн цаас, шохой, бал, маркер, принтерийн хор, судлагдахууны онцлогтой туршилт, дадлагын химийн урвалж бодис, технологийн хичээлийн бэлдэц, мод, материал, бөмбөг зэрэг бага үнэтэй, түргэн элэгдэх хангамжийн материал, хэрэгслийн зардал;

3.4.7.ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын танхимаас гадуурх хичээл, сургалтын үйл ажиллагаанд шаардагдах зарим зардал;

3.4.8.сургалтын байгууллагын сургалтад ашиглагдах суурин болон зөөврийн компьютер, цахим хэрэглэгдэхүүн, лабораторийн тоног төхөөрөмж, тавилга, багаж, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, цэцэрлэгийн хүүхдийн тоглоом, зөөлөн эдлэл гэх мэт нөхөн хангалтын зардал;

3.4.9.Боловсролын ерөнхий хуулийн 13.2.8-д заасан ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах хүүхэд хамгааллын зардал;

3.4.10.суралцагчийн сурах чадвар, авьяас сонирхлыг хөгжүүлэх, хоцрогдол нөхөх, ахисан түвшний агуулга эзэмших, ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хөгжил, төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталж, үндэсний хэмжээнд цахим болон танхимаар хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагаа, зохион байгуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт хөтөлбөрийн зардал.

3.5.Суурь болон бусад хувьсах зардлын дундаж хэмжээний бүрэлдэхүүнд заасан зардлыг энэ журмын хавсралтаар баталсан зааврын дагуу санхүүжүүлнэ.



3.6.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хувьсах зардлын дундаж хэмжээг инфляци, цалин хөлс болон эдийн засгийн өсөлтийн дундаж хэмжээг харгалзан Боловсролын ерөнхий хуулийн 24.1.6-д заасны дагуу шинэчлэн тогтоох санал боловсруулан, шийдвэрлүүлж, шаардлагатай санхүүжилтийг улсын төсвийн төсөлд тусгана.

Дөрөв.Хувьсах зардлын дундаж хэмжээнд тохируулга хийх

4.1.Сургалтын хөтөлбөрийн болон сургалт явуулж байгаа арга хэлбэрийн онцлогийг харгалзан хувьсах зардлын дундаж хэмжээнд доор дурдсан тохируулга хийж төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч хуваарилалт хийнэ:

4.1.1.төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн байршил, хүүхдийн тооноос хамаарсан итгэлцүүр, сургалтын хөтөлбөрийн онцлогийг харгалзан тухайн сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээнд Засгийн газраас баталсан итгэлцүүрийг үндэслэн тохируулга хийх;

4.1.2.Баян-Өлгий аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг 1 хувиар нэмэгдүүлж тооцох;

4.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хувилбарт сургалтын нүүдлийн бүлэгт хамрагдах нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээний 25 хувийг, явуулын багшийн сургалтад хамрагдах нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээний 20 хувийг тус тус олгох (энэ зардлын 80 хүртэл хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, үлдсэн хувийг бусад зардалд зарцуулна);

4.1.4.өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, хүүхдэд ногдох хувьсах зардлыг гурав дахин нэмэгдүүлж тооцох;

4.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамаарсан боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг 75 хувь, цэцэрлэгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг 30 хувиар тус тус нэмэгдүүлж тооцох¹;

¹ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 18.5



4.1.6. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 19.3-т заасан уртасгасан цагаар сургалт, үйл ажиллагаагаа явуулдаг цэцэрлэгийн санхүүжилтийг 30 хувиар, цэцэрлэгийн зарим бүлэг нь уртасгасан цагаар сургалт, үйл ажиллагаа явуулдаг бол тухайн бүлгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг 38 хувиар тус тус нэмэгдүүлж олгох;

4.1.7. дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж байгаа суралцагчийн зардлыг суурь хувьсах зардлаар тооцож санхүүжүүлэх;

4.1.8. цэцэрлэгийн хүртээмж багатай байршлын хамран сургах тойргийн хүүхдийг элсүүлсэн төрийн бус өмчийн цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг энэ журмын 4.1.4-т заасны дагуу санхүүжүүлэх.

4.2. Үндэсний хэмжээнд нийтлэг мөрдөгдөж байгаа хөтөлбөрөөс ялгаатай нэмэлт хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловсролын байгууллагад энэ журмын 3.4.10-д заасан зардлыг хөтөлбөр, арга хэмжээний итгэлцүүр хэрэгжих хугацаанд үндэслэн тухайн сургалтын байгууллагын төсөвт нэмж хуваарилна.

4.3. Ахлах ангийн сонголттой хичээлийн цахим сургууль (виртуал)-д суралцсан нэг сурагчийн зардлыг хувьсах зардлын нэг судлагдахуунд ногдох өртгөөр тооцно.

4.4. Ерөнхий боловсролын сургуульд бүлэг дүүргэлтийн батлагдсан стандарт, нормативын дээд хязгаараас хэтэрсэн ачаалалтай ажиллаж байгаа бага ангийн багшид тухайн байгууллагын батлагдсан төсөвт багтаан² нэмэгдэл хөлс олгох, эсхүл багшийн туслах ажиллуулж болно. Уг нэмэгдлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 109.6-д заасны дагуу сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.

4.5. Энэ журмын 4.4-т заасан нэмэгдэл хөлс олгох хэмжээг тогтоохдоо Багшийн хөгжлийн тухай хуулийн 8.4-т заасан хязгаар хүртэлх суралцагчийн тооноос хэтрүүлэхгүй, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээний 0.1 хүртэлх хувьтай дүйцэх хэмжээнд тооцож нэмэгдүүлнэ.

4.6. Сургалтын байгууллагын дундаж бүлэг дүүргэлт нь 45 ба түүнээс дээш байх тохиолдолд нэг багшид ногдох ачааллыг бууруулах зорилгоор хэтэрсэн ачаалалтай хэсэгт нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээний 70 хүртэл хувиар бууруулж сургалтын байгууллагад санхүүжилтийг олгож болно. Цалингийн сангийн хэмжээ нь

² Төсвийн тухай хуулийн 6.4.8



тооцсон цалингаас 30 болон түүнээс дээш хувиар хэтэрсэн тохиолдолд төсвийн төвлөрүүлэн захирагч тухайн байгууллагын цалингийн санг бодит цалингаар нь тооцон зохицуулалт хийнэ.

4.7.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохирц, нийцлийг туршиж байгаа Боловсролын ерөнхий хуулийн 17.4-т заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурь хувьсах зардлыг 30 хувиар нэмэгдүүлж санхүүжүүлнэ.

4.8.Энэ журмын 4.6-д заасан төсвийн өөрчлөлт, зохицуулалтыг төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч хэрэгжүүлж болно.

4.9.Энэ журмын 4.2-т заасан нэмэлт хөтөлбөр хэрэгжих хугацаанд анги, бүлэг, суралцагчийн тоо нэмэгдсэн тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийж болно.

Тав.Суралцагчийн тоо

5.1.Төсвийн жилд хамрагдах суралцагчийн тоо нь дуусах хичээлийн жилд хамрагдах 6 сар болон ирэх хичээлийн жилд хамрагдах 4 сард суралцах хүүхдийн тооны нийлбэрийг хичээлийн жилийн нийт үргэлжлэх хугацаанд хуваасантай тэнцүү байна.

5.2.Төсвийн жилд суралцагчийн тоог ерөнхий боловсролын сургуулийн анги бүрд хамрагдах хүүхдийн тоогоор, цэцэрлэг болон дотуур байрны нийт хүүхдийн тоогоор тооцно.

Зургаа.Багш, ажилтны орон тоо

6.1.Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай багшийн орон тоог тухайн хичээлийн жилийн суралцагчийн тоо, тооцсон бүлэг (бүлэг дүүргэлтийн норм болон зөвшөөрөгдөх интервалыг харгалзах бөгөөд бага 20, дунд 20-35, ахлах 20-40 хооронд гэх мэт), хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөөг үндэслэн тодорхойлно.

6.2.Багшийн долоо хоногт танхимаар заах хичээлийн цагийн норм нь эрх бүхий байгууллагаас баталсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм болон багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журамд зааснаар тодорхойлогдоно.



6.3.Тухайн хичээлийн жилд ажиллах боломжит багш болон багшаас бусад ажилтны орон тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын төлөвлөгөө, Засгийн газраас тогтоосон сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын норм, нормативд үндэслэн, батлагдсан төсвийн хүрээнд³ сургалтын байгууллагын захирал, эрхлэгч тогтооно.

6.4.Хичээлийн долоо хоногийн нийт цагийг судлагдахууны чиглэл⁴ бүрээр тодорхойлох бөгөөд бага ангийн багшийн сургалтын цагт бэлтгэл хөтөлбөр, монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, иргэний ёс зүйн боловсрол, хүн орчин, хүн нийгэм, хүн байгаль, зураг зүйн хичээлийн төлөвлөгөөт цагаас бүрдэнэ. Дунд, ахлах ангийн багшийн сургалтын цагийг нийт дүнгээр тооцох бөгөөд бага ангийн биеийн тамир, хөгжим, англи хэлний хичээлийн цагийг нэмнэ.

6.5.Сургуулийн сургалтын цагийг долоо хоногийн багшийн цагийн нормд харьцуулан шаардлагатай багшийн тоог⁵ судлагдахууны чиглэл бүрээр тооцно.

6.6.Багшийн нийт сургалтын цагийг тооцохдоо дараах хүснэгтэд заасан байдлаар судлагдахууныг бүлэглэнэ:

<i>Судлагдахууны чиглэл</i>	<i>Хамаарах анги</i>
<i>Монгол хэл, Үндэсний бичиг, Уран зохиол</i>	6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Казах хэл, Казах уран зохиол</i>	6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Математик</i>	6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Мэдээллийн технологи*</i>	6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Физик</i>	6, 7, 8, 9, 10, 11
<i>Биологи, Эрүүл мэнд</i>	6, 7, 8, 9, 10, 11
<i>Хими</i>	6, 7, 8, 9, 10, 11
<i>Нийгэм, Иргэний ёс зүйн боловсрол, Түүх</i>	6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Газар зүй</i>	7, 8, 9, 10, 11
<i>Англи хэл*</i>	5, 6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Орос хэл*</i>	7, 8, 9
<i>Биеийн тамир</i>	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Хөгжим</i>	6, 7, 8, 9
<i>Зураг зүй, технологи*</i>	6, 7, 8, 9, 10, 11, 12
<i>Сонгох хичээл</i>	10, 11, 12

³ Төсвийн тухай хуулийн 6.4.8

⁴ "судлагдахууны чиглэл" гэж шаардлагатай багшийн сургалтын цагийг тооцохдоо сургуулийн хэмжээнд нэгтгэж бодох боломжит хэд хэдэн хичээлийн нэгдлийг ойлгоно.

⁵ "шаардлагатай багшийн тоо" гэж боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу тухайн сургуульд хичээл заах, хүний нөөцийн болон цалин хөлсний системд бүртгэгдэх, төсвийн жилийн цалингийн санг тооцох нийт багшийн тоог ойлгоно.

*Дэд бүлгээр хичээллэхээр тооцож болно.

6.7. Шаардлагатай багшийн тоог анги тус бүрээр нэгтгэн дараах томъёогоор тооцон гаргана:

$$CS_a = \left(\left(\frac{CH_a^g}{TW^g} \right) * TN^g \right)$$

CS_a = а судлагдахуун бүлэглэлийн нийт шаардлагатай багшийн тоо;

CH_a^g = а судлагдахууны бүлгийн g ангийн албан ёсны сургалтын судлагдахуун төлөвлөгөөний дагуу жилийн нийт хичээллэх цагийн тоо;

TW^g = g хамаарах ангийн хичээлийн жилийн хичээллэх долоо хоногийн тоо;

TN^g = g хамаарах ангийн нийт бүлгийн тоо;

$$TCS_i = TCS_{(i-1,i)} + \Delta TCS_{(i,i+1)}$$

TCS_i = i онд шаардлагатай нийт багшийн тоо;

$TCS_{(i-1,i)}$ буюу тухайн оны эхний хичээлийн жилийн хичээлийн хөтөлбөр, бүлгийн тооноос хамаарсан шаардлагатай багшийн тоо;

$TCS_{(i,i+1)}$ буюу тухайн оны сүүлийн хичээлийн жилийн бүлгийн тооны өөрчлөлтийг тооцсон шаардлагатай багшийн тооны өөрчлөлт.

Долоо. Зардал төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх

7.1. Төсвийн шууд захирагч нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээгээр тооцож, төсвийн төслөө боловсруулан аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, дүүргийн Боловсролын хэлтэст хүргүүлэх бөгөөд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, дүүргийн Боловсролын хэлтэс, Нийслэлийн боловсролын газар, төсвийн төвлөрүүлэн захирагч саналыг хянан, нэгтгэж, харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.

7.2. Төсвийн ерөнхийлөн захирагч хувьсах зардлын дундаж хэмжээг энэ журмын 3.6-д заасны дагуу шинэчлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх, улсын хэмжээнд нэгтгэсэн төсвийн саналыг эцэслэн батлуулах ажлыг зохион байгуулна.

7.3. Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч батлагдсан төсвийг хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэлд үндэслэн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээгээр тооцож цэцэрлэг, сургууль тус бүрээр батална.



7.4.Баталсан санхүүжилтийн хуваарийн дагуу хувьсах зардлын санхүүжилтийг сар бүр тухайн сургууль, цэцэрлэгийн дансанд шилжүүлнэ.

7.5.Нэг суралцагчид ногдох зардлын дундаж хэмжээгээр олгох санхүүжилтийн гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр⁶ хянаж хагас, бүтэн жилээр тооцон, зохих өөрчлөлтийг тусган төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн шийдвэрээр санхүүжүүлнэ.

7.6.Улсын хэмжээнд болон тухайн орон нутагт өндөржүүлсэн, бүх нийтийн бэлэн байдал, онцгой нөхцөл тогтоосон үед боловсролын байгууллагын танхимын сургалтыг теле болон цахим хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тухайн хичээлийн жилийн албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн хуваарилна.

7.7.Төрийн болон орон нутгийн өмчийн сургалтын байгууллагын тавилга, тоног төхөөрөмж, цэцэрлэгийн тоглоом, зөөлөн эдлэл, бусад тоног төхөөрөмж гэх мэт нөхөн хангалтын зардал хуваарилах, гүйцэтгэлийг хангуулахад дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

7.7.1.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нөхөн хангалтын зардлыг хүүхэд бүрд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх зорилгоор нэг суралцагчид ногдох нийт хувьсах зардал (өсөн нэмэгдүүлэх итгэлцүүр тооцоогүй дүн), хичээлийн жилийн албан ёсны статистик мэдээлэлд үндэслэн хуваарилах;

7.7.2.төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх олгосноор төсвийн төвлөрүүлэн захирагч боловсролын салбарын сургалтын хэрэглэгдэхүүний өнөөгийн төлөв байдлын судалгааны дүнг харгалзан шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолтыг боловсруулж, батлах, шаардлагатай сургалтын тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг эрх бүхий байгууллагатай хамтран ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах;

7.7.3.төсвийн шууд захирагч тухайн сургалтын байгууллагад хуваарилагдах тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хэрэгцээг эрэмбэлж, үе шаттай шийдвэрлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

7.7.4.төсвийн шууд захирагч энэ журмын 7.7.3-т заасны дагуу шийдвэрийн төслөө өөрийн удирдлага буюу эцэг, эхийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тус зөвлөлийн санал, дүгнэлтээр дэмжигдсэн жагсаалтыг баталснаар худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулж, тайлагнах;

⁶ “хүүхэд өдөр” гэж тодорхой хугацааны доторх хуанлийн нийт ажлын өдөр ба хамрагдах суралцагчийн тооны үржвэрийг ойлгоно.



7.7.5.төсвийн шууд захирагч ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллагаас холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

7.8.Энэ журмын 7.7-д заасан хэсэг нь төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг болон төрийн өмчийн шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмжийн хангалт, нөхөн хангалтад хамаарахгүй.

7.9.Төсвийн ерөнхийлөн захирагч нь батлагдсан төсөвт багтаан бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор журмын 7.7.1-д заасан нөхөн хангалтын зардлыг хүүхдийн тоо, алслагдсан байдал, хэв шинжээс хамааруулан тохируулга хийх замаар тэгш боломжийг бүрдүүлж болно.

Найм.Хувьсах зардлын дундаж хэмжээгээр төсөв тооцох, зохицуулах чиглэл

8.1.Сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээний санхүүжилт олгоход шаардагдах мэдээ, тайланг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

8.2.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын удирдлага хувьсах зардлын дундаж хэмжээгээр тооцон хуваарилсан санхүүжилтийг зарцуулахдаа дараах чиглэлийг баримтална:

8.2.1.хичээл, сургалтын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдах нөхцөлийг хангах;

8.2.2.сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллагаас баталсан орон тооны хязгаар болон зардлын норм, нормативыг чанд мөрдөх;

8.2.3.хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай багшийн орон тоог тухайн хичээлийн жилийн суралцагчдын тоо, тооцсон бүлэг (анги тус бүр)-ийн тоонд үндэслэн бүлэг дүүргэлтийн нормын дагуу тооцож хамгийн бага байхаар сургалтын төлөвлөгөөг оновчтой баталж, мөрдүүлэх;

8.2.4.багшийн цалин хөлс, урамшууллыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэл, үр дүнг харгалзан тухайн сургалтын байгууллагын баталсан жилийн төсөвт багтааж олгох;

8.2.5.багшийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалт хийх, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, шийдвэр гаргахад тухайн сургууль, цэцэрлэгийн зөвлөлд танилцуулж, зөвлөлийн саналаар хамгийн өндөр эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

8.2.6.сургалтын байгууллагын төсөв хуваарилах, хэрэгжүүлэхэд ил тод байдал болон эцэг эхийн зөвлөл, олон нийтийн оролцоог хангах.

8.3.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, бусад ажилтны цалин хөлсийг олгоход дараах зохицуулалтыг мөрдлөг болгоно:

8.3.1.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цалингийн санд багш, багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, анги даасан, кабинет, лаборатори хариуцан ажилласан, мэргэжлийн багш нарын бүлэг удирдсаны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдэл, Засгийн газрын тогтоолоор баталсан бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тус тус багтана;

8.3.2.цалингийн санг тооцохдоо цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагатай холбоотой эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, тушаал, шийдвэр, норм, норматив, стандартын дагуу тооцсон үндсэн цалин, гүйцэтгэлийн урамшуулал болон бусад Засгийн газрын тогтоолоор баталсан нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тус тус багтана;

8.3.3.шаардлагатай багшийн орон тоог энэ журмын 6-д заасны дагуу тооцно;

8.3.4.ерөнхий боловсролын сургалтын байгууллагын дэд бүтцийн хүчин чадлын ашиглалт хэт өндөр, бүлэг дүүргэлтийн стандартаас хэтэрсэн ачаалалтай ажиллаж байгаа бага ангийн багшид (багшийн туслах) илүү хүүхэдтэй ажилласан нэмэгдэл хөлс олгож болно.

8.4.Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.

8.5.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээнд үндэслэн олгосон санхүүжилтийг зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах үүрэгтэй.

8.6.Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээгээр олгосон санхүүжилтийн жилийн эцсийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн сургалтын байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан тавилга, хэрэгсэл, тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл (урсгал засвар) гэх мэт шийдвэрлэх, багшийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах зориулалтаар цэцэрлэг, сургууль бие даан зохих хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж болно.

8.7.Энэ журмын 8.6 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ сургалтын байгууллагын өөрийн удирдлага, хамт олны 2/3-оос доошгүй ирцтэй хурлаар хэлэлцүүлэн төсвийн шууд захирагч шийдвэр гаргана.

8.8.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн тухай хуулийн 4.2-т заасны дагуу тухайн төсвийн жилд 2 нас хүрэх хүүхдийг элсүүлсэн тохиолдолд энэ журмын 9.5-д заасан болон боловсролын албан ёсны статистик мэдээллийг үндэслэн санхүүжүүлнэ.

Ес.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хувьсах зардлын дундаж хэмжээгээр төсөв тооцож, зардал хуваарилах

9.1.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардалд төрөөс олгох санхүүжилтийн хэмжээг тухайн жилийн төсвийн төсөлтэй хамт ирүүлсэн сургалтын төлбөр⁷ тогтоосон шийдвэр, Засгийн газраас баталсан сургалтын төлбөрөөс хамаарах итгэлцүүрийг тус тус баримтлан тооцно.

9.2.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төсвийн төслийн саналыг энэ журамд нийцүүлэн жилээр төлөвлөж, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэст холбогдох хуульд заасан хугацаанд нэгтгэж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ.

9.3.Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын хуулийн этгээдийн гэрчилгээ, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, сургалтын төлбөр тогтоосон албан ёсны шийдвэрийн хуулбар нь төсвийн төслийн салшгүй хэсэг байна.

⁷ “төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлбөр” гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтан болон зөвлөл, хурлын шийдвэрээр баталгаажсан, аливаа хөнгөлөлт, чөлөөлөлт тооцоогүй бүтэн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг ойлгоно.



9.4.Тухайн төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төсвийг хичээлийн жилийн боловсролын албан ёсны статистик мэдээ болон сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хавсралтаар баталсан хүүхдийн тоог харгалзан хянана.

9.5.Санхүүжилт олгох хүүхдийн тооны дундаж нь тухайн хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоо болон сургалт эрхлэх тусгай зөвшөөрлөөр баталсан хүүхдийн тооноос ихгүй байна.

9.6.Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянасан ирцийн мэдээг төсвийн төвлөрүүлэн захирагчид сар бүрийн 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

9.7.Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардлыг энэ журмын 9.6-д заасан ирцийн мэдээнд үндэслэн хувьсах зардлын 80 хувийг сар бүр олгох бөгөөд гэрээний үр дүнд үндэслэн үлдэгдэл 20 хүртэлх хувийг хагас болон бүтэн жилээр олгоно.⁸

9.8.Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлбөрийн хэмжээ нь анги бүрд ялгаатай тохиолдолд сургалтын төлбөрийн хэмжээнээс хамаарсан харгалзах итгэлцүүрээр тооцож хуваарилна.

Арав.Төсвийн гүйцэтгэл, төлбөр тооцоо, тайлагналт

10.1.Хувьсах зардлаар санхүүжиж байгаа төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу төсвийн төвлөрүүлэн захирагч нэгтгэн тайлагнана.

10.2.Төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргахдаа санхүүгийн программаар боловсруулж, мөнгөн гүйлгээний тайланд тохируулга хийж бэлтгэнэ.

10.3.Төсвийн тухай хууль, холбогдох эрх зүйн актын хүрээнд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэс сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хянан, нэгтгэж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ.

10.4.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хөрөнгийн өөрчлөлтийг тухай бүр Боловсролын мэдээллийн нэгдсэн санд оруулж, тайлагнана.

⁸ Боловсролын ерөнхий хуулийн 38.10



Арван нэг.Хяналт

11.1.Төрийн сан нь төсвийн зарцуулалтыг хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар хянаж, санхүүжүүлнэ.

11.2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас өгсөн чиглэл, батлагдсан төсвийн хуваарилалт, энэ журмын дагуу аймаг, нийслэл, дүүргийн боловсролын удирдлагын байгууллагууд, тэдгээрийн санхүү, төсөв, гүйцэтгэл хариуцсан нэгж, албан хаагчид төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналтыг удирдан зохион байгуулна.

11.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтэс нь төрийн сангийн төлбөр тооцоо, цалингийн нэгдсэн системээр дамжуулан төсвийн хуваарилалт, санхүүжилт, үр дүнгийн гүйцэтгэлд хяналт тавина.

Арван хоёр. Бусад

12.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсролын сургалтын байгууллагын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэл, тайлагналтыг цахим мэдээллийн системд үндэслэн гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн байна. Цахим систем нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд ашиглаж байгаа цахим системтэй мэдээлэл солилцох, харилцан уялдаатай ажиллах боломжтой байна.

12.2.Төрийн албаны цалингийн мэдээллийн систем дэх цалингийн гүйцэтгэлийн мэдээллийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон боловсролын мэдээллийн системд хөрвүүлж авах бөгөөд энэ нь салбарын орон тоо, цалингийн сангийн албан ёсны суурь мэдээлэл болно.

12.3.Төрийн сангийн төлбөр тооцооны системийн мэдээлэлд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программаар боловсруулсан боловсролын салбарын байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгож, дараа сарын 05-ны өдрийн дотор боловсролын мэдээллийн системд хөрвүүлсний үндсэн дээр салбарын төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэнэ.

---o0o---

Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журмын хавсралт

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭНИЙ БҮРЭЛДЭХҮҮН, ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ЗААВАР

№	Зориулалт, арга хэмжээ	Зардлын дэлгэрэнгүй тайлбар	Эдийн засгийн ангилал
1.	Шаардлагатай багшийн тоо, орон тооны жишиг нормативаар тооцсон захиргаа, аж ахуйн ажилтны тоонд хамаарах үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээний цалингийн санд багш, ажилтны үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, заах аргын нэгдэл удирдсаны нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд үйлчилгээ үзүүлсний нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, гүйцэтгэлийн урамшууллаас бусад Засгийн газрын тогтоолоор баталсан нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэдгээрт ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тус тус багтана.	Цалин хөлс, урамшууллын зардлын бүлэгт хамаарна
2.	Сургуулийн үйл ажиллагааны урсгал зардал (Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх)	Байгууллагын хэвийн үйл ажиллагааны зардалд захиргааны бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолт, бараа үйлчилгээний бусад, төлбөр хураамж, даатгал, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардал гэх мэт зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад (бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолт, төлбөр хураамж гэх мэт)
3.	Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал (Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх)	Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал
4.	Эрүүл мэндийн үйлчилгээний зардал (Эрүүл мэндийг дэмжих)	Эрүүл мэндийн үйлчилгээнд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан шийдвэрийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арьс өнгө, сүрьеэ, цагаан хорхой, нян тээгч илрүүлэх үзлэг, шинжилгээ, эрүүл мэндийн даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий лавлагаа (ахисан) шатлалын (60/40) байгууллагатай хамтран боловсруулах “Багш” багш бус ажилтан багцын үзлэг, шинжилгээ, даатгалын зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал
5.	Цахим хэрэглээний зардал (Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх)	Цахим хэрэглээний зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай цахим систем, дата, цахим эрх, мэдээллийн технологи, дотоод сүлжээ болон интернэт үйлчилгээ болон нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал багтана.	Мэдээлэл технологийн үйлчилгээ

6.	Анги танхимын ариутгал, цэвэрлэгээний зардал (Байр ашиглалтын үйлчилгээ)	Ариутгал, цэвэрлэгээ, сургуулийн нийтийн эзэмшлээс бусад анги танхимын үйлчилгээ, цэвэрлэгээний зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал
7.	Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардал (Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх)	Хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, багшийн сургалтад шаардлагатай орчныг бий болгох зориулалттай зардал байна. Хичээл, практикийн зардалд лаборатори, кабинетын сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтад байхгүй материал, бичгийн цаас, шохой, бал, маркер, принтерийн хор, судлагдахууны онцлогтой хэрэглэгдэх, туршилт дадлагын явцад шаардагдах химийн урвалж бодис, технологийн хичээлийн бэлдэц, мод материал, сагсан бөмбөг, хөл бөмбөг, тугалган цаас, лаа, зай, хадаас, оёдлын утас, даавуу гэх мэт хөрөнгийн бус хангамжийн материал багтана.	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх
8.	Танхимаас гадуурх хичээл сургалтын үйл ажиллагааны зардал (Сургалт семинар)	Танхимын бус сургалтын үйл ажиллагааны зардалд суралцагчдыг сургуулиас гадна музей, номын сан, түүхийн дурсгалт газарт түшиглэн танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал
9.	Сургалтын тоног, төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн нөхцөлийг хангах, сургалтын биет орчны батлагдсан стандартад үе шаттай нийцүүлэхэд зайлшгүй шаардлагатай (суурин болон зөөврийн компьютер, цахим хэрэглэгдэхүүн, түүний дагалдах хэрэгсэл, байгалийн ухааны лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, биет үзүүлэн болон сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт) зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах дундаж хугацаа, нэг суралцагчид тухайн жилд ногдох өртөг буюу элэгдлийн зардлыг нөхөх зорилгоор санхүүжүүлж буй сургалтын тоног төхөөрөмж, цэцэрлэгийн зөөлөн эдлэл, тоглоом худалдан авах, эзэмших, ашиглах, санхүүгийн түрээсийн хэлбэрээр санхүүжүүлэх зардал багтана.	Бараа, үйлчилгээний бусад зардал (багаж хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж гэх мэт)
10.	Хүүхэд хамгааллын зардал	Хүүхэд хамгааллын зардалд хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх, зөвлөх, туслах арга хэмжээг зохион байгуулах багийн үйл ажиллагааны зардал, урамшуулал, шуудан холбооны зардал, багаж техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бага үнэтэй түргэн элэгдэх зардал, замын зардал, бичиг хэрэгсэл. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, шуурхай тусламжийн болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардал.	Бараа, үйлчилгээний бусад зардал

----000----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.10-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах, гэрэл зураг, дүрс бичлэг хийх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

СОЁЛЫН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ч.НОМИН



Засгийн газрын 2024 оны 01 дүгээр
сарын 25-ны өдрийн 40 дүгээр
тогтоолын хавсралт

НИЙТИЙН ӨМЧИЙН СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ХУВИЛАН ОЛШРУУЛАХ, ГЭРЭЛ ЗУРАГ, ДҮРС БИЧЛЭГ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах, гэрэл зураг авах, дүрс бичлэг хийхтэй холбогдсон үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах, гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх үйл ажиллагаанд Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Музейн тухай, Зөвшөөрлийн тухай, Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж болон энэ журмыг мөрдөнө.

1.3.Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах, гэрэл зураг авах, дүрс бичлэг хийхэд дараах зарчмыг баримтална:

1.3.1.урьдчилан зөвшилцсөн байх;

1.3.2.соёлын биет өвд хохирол учруулахгүй байх;

1.3.3.харилцан ашигтай байх.

1.4.Хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн ул мөрийг бэхжүүлэх, нотлох баримт цуглуулах зэрэг зорилгоор нийтийн өмчийн соёлын биет өвийн гэрэл зураг авах, дүрс бичлэг хийхэд энэ журмыг мөрдөхгүй.

Хоёр.Соёлын биет өвийг хувилан олшруулах

2.1.Иргэн, хуулийн этгээд нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах үйл ажиллагааг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 53.1-д зааснаар соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний олгосон зөвшөөрлийг үндэслэн хэрэгжүүлнэ.

2.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулах зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нийтэд мэдээлэх асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.



2.3.Иргэн, хуулийн этгээд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хувиран олшруулах үйл ажиллагааг эзэмшигч байгууллагатай нь, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хувиран олшруулах үйл ажиллагааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэнэ. Гэрээнд хувиран олшруулах үйл ажиллагааг гүйцэтгэх хугацаа, хувиран олшруулах тоо хэмжээ, санхүүжилт, хувиран олшруулсан эхийг ашиглах нөхцөл, талуудын эрх, үүргийг тусгана.

2.4.Хувиран олшруулсан эхийн нүдэнд үл харагдах хэсэгт “ХУУЛБАР /..он..” гэсэн бичвэрийг арилахгүй, устахгүй байхаар бичнэ.

2.5.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 53.5-д зааснаар 1:1 масштабаар хувиран олшруулсан эхийг давтан олшруулахгүй.

2.6.Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувиран олшруулахад ашигласан хэв, дардас, бусад зүйлийг гэрээнд оролцогч талуудыг байлцуулан нэн даруй устгалд оруулна.

Гурав.Гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх

3.1.Иргэн, хуулийн этгээд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх бол хүсэлтээ тухайн ажил эхлэхээс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч байгууллагад гаргана.

3.2.Нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг судалж, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хугацаанд хариуг хүргүүлнэ.

3.3.Нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг эзэмшигч гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх зорилгоор түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.11-д заасан зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна.

3.4.Нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг эзэмшигч нь иргэн, хуулийн этгээдээс түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх хүсэлт гаргасан бол соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

3.5.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг эзэмшигч нь энэ журмын 3.1-д заасан



гэрэл зураг авах, дүрс бичлэг хийлгэх үйлчилгээг төлбөртэй үзүүлж болно. Төлбөрийн хэмжээг үүсгэн байгуулагчтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр эзэмшигч байгууллагын удирдлага тогтооно.

3.6.Иргэн, хуулийн этгээд ашиг олох зорилгоор музей, галерейн зориулалтаар ашиглаж байгаа нийтийн өмчийн түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын гадаад, дотоод орчны гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх, түүнчлэн нисдэг төхөөрөмж ашиглан соёлын биет өвийн гэрэл зураг, дүрс бичлэг хийхэд тухайн дурсгалыг ашиглаж байгаа хуулийн этгээдэд урьдчилан мэдэгдэнэ.

3.7.Иргэн, хуулийн этгээд дараах тохиолдолд энэ журмын 2.1-д заасан зөвшөөрөлгүйгээр нийтийн өмчийн соёлын биет өвийн гэрэл зураг авч, дүрс бичлэг хийж болно:

3.7.1.энэ журмын 3.6-д зааснаас бусад нийтийн өмчийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх;

3.7.2.гар утас ашиглан төрийн болон орон нутгийн өмчийн музей, галерейн үзүүлэгийн танхимд дэлгэсэн нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх;

3.7.3.эзэмшигчийн захиалгаар нийтийн өмчийн соёлын биет өвийг судлах, сэргээн засварлах үйл явцыг баримтжуулах;

3.7.4.соёлын биет өвийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг бүхий хуулийн этгээд бүртгэл мэдээллийн санд хадгалах зорилгоор өөрийн эзэмшлийн нийтийн өмчийн соёлын биет өвийн гэрэл зургийг авах, дүрс бичлэгийг хийх.

3.8.Нийтийн өмчийн соёлын биет өвийн гэрэл зураг, дүрс бичлэгийг дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан аливаа хэвлэлийн бүтээгдэхүүн, кино, видео контентод ашиглахгүй.

Дөрөв.Бусад зүйл

4.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувилан олшруулсан, энэ журамд заасны дагуу гэрээ байгуулж зураг авсан, дүрс бичлэг хийсэн талаарх мэдээллийг соёлын биет өвийн бүртгэлд бүртгүүлж, мэдээллийн санд хадгална.

4.2.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.

----oOo----

дээрх гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

Тус гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

1.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

2.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

3.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

4.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

5.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

6.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

7.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр

8.0. Гэрээний гүйцэтгэлээр
2024 оны 12 сар 31-ийн өдөр
2024 оны 12 сар 31-ийн өдөр



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар тогтоолын хавсралт

ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГАСАН ХҮНИЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, БИОБЭЛДМЭЛ, ВАКЦИНЫГ ГАДААД УЛСЫН ҮЙЛДВЭРЛЭГЧЭЭС, ЭСХҮЛ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ШУУД БОЛОН ДАМЖУУЛАН ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.1.2-т заасан олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг (цаашид “эм, эмнэлгийн хэрэгсэл” гэх) гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авахад нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэх (цаашид “нэг эх үүсвэрээс худалдан авах” гэх) харилцааг зохицуулна.

1.2.Олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас худалдан авах ажиллагааг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, үйлдвэрлэгчээс худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.1, 45.2, 45.4, 45.7-д заасны дагуу тус тус зохион байгуулна.

1.3.Энэ журмын хүрээнд олон улсын чанарын шаардлага хангасан болохыг эрх бүхий этгээдээс тогтоосон нотлох баримт бүхий дараах эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг зохицуулна:

1.3.1.төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагын иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл;

1.3.2.төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм;

1.3.3.иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнээр олгох эм;

1.3.4.өрхийн эрүүл мэндийн төвийн өдрийн эмчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл.

1.4.Гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах эм нь дараах чанарын шалгуурыг хангасан байна:



1.4.1.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын урьдчилсан баталгаажилтад хамрагддаг эмийн хувьд урьдчилсан баталгаажилттай байх;

1.4.2.ДЭМБ-ын эмийн зохицуулалтын төлөвшил нь 3 болон түүнээс дээш түвшингээр үнэлэгдсэн улсад үйлдвэрлэгдсэн байх;

1.4.3.үйлдвэрлэгч улсын зах зээлд тухайн эмийг хэрэглэдэг байх;

1.4.4.үйлдвэрлэгч нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) хангасан эм байх.

1.5.Гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах эмнэлгийн хэрэгсэл нь дараах чанарын шалгуурыг хангасан байна:

1.5.1.эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч нь олон улсын ISO 9001, ISO 13485 стандартын шаардлага хангасан байх;

1.5.2.эмнэлгийн хэрэгсэл нь 3 болон түүнээс дээш улсад нийлүүлэгддэг байх;

1.5.3.Үйлдвэрлэгч улсын зах зээлд тухайн эмнэлгийн хэрэгслийг хэрэглэдэг байх (Free sale certificate).

Хоёр.Эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, төрөл сонгох, хэрэгцээ тодорхойлох

2.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг эрүүл мэндийн байгууллагуудын тухайн онд худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн тайлан, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлсэн эмийн мэдээлэл, энэ журмын 2.2-т заасан зарчмыг үндэслэн гаргана.

2.2.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгохдоо дараах зарчмыг баримтална:

2.2.1.эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг, эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл;

2.2.2.тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай, тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл.



2.3.Эрүүл мэндийн байгууллагууд тухайн онд худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараах байдлаар хүргүүлнэ:

2.3.1.аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагууд болон өрхийн эрүүл мэндийн төвийн нэгдсэн тайланг;

2.3.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагууд өөрийн байгууллагын тайланг;

2.3.3.эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлсэн эмийн нэр, төрөл, тоо хэмжээний өмнөх оны гүйцэтгэлийг.

2.4.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус хүргүүлнэ.

2.5.Эрүүл мэндийн байгууллагууд эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн нэр, төрөлд үндэслэн нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараах байдлаар хүргүүлнэ:

2.5.1.аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагууд болон өрхийн эрүүл мэндийн төвийн нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, төрөл, тун, тоо хэмжээ, төсвийн тооцоолол;

2.5.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагууд өөрийн байгууллагын нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, төрөл, тоо хэмжээ, төсвийн тооцоолол;



2.5.3.эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэг эх үүсвэрээс худалдан авах эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн нэр, төрөл, тоо хэмжээ, төсвийн тооцоолол;

2.5.4.Халдварт өвчин судлалын үндэсний төв нэг эх үүсвэрээс худалдан авах вакцины нэр, төрөл, тоо хэмжээ, төсвийн тооцоолол.

2.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг улсын хэмжээнд нэгтгэн жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.7.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээг 3 хүртэлх жилээр баталж, тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлнэ.

2.8.Энэ журмын 2.7-д заасан жагсаалтыг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус бүрээр батална.

Гурав.Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гэрээ байгуулах

3.1.Эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

3.1.1.эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, төрөл, хэрэгцээг олон улсын байгууллагад хүргүүлж, үнийн санал авах, төлбөрийн нөхцөлийг харилцан тохиролцох;

3.1.2.эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олон улсын байгууллагаас ирүүлсэн үнийн саналыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж, санал авах;



3.1.3.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн үнийн санал, төлбөрийн нөхцөлийг үндэслэн олон улсын байгууллагад худалдан авах захиалга хүргүүлэх.

3.2.Эм, эмнэлгийн хэрэгслийг гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна:

3.2.1.олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах боломжгүй эм, эмнэлгийн хэрэгслийг гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах;

3.2.2.гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.1, 45.2, 45.4, 45.7-д заасны дагуу зохион байгуулна.

3.3.Нэг эх үүсвэрээс худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд захиалагч нь эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байна.

3.4.Ханган нийлүүлэх байгууллага нэг эх үүсвэрээс худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, үйл ажиллагаандаа хадгалалт, түгээлтийн стандартыг дагаж мөрдөх талаар гэрээнд тусгана.

Дөрөв.Санхүүжилт

4.1.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийг эрүүл мэндийн байгууллагууд, вакцины төлбөрийг Эрүүл мэндийн сайдын багцаас тус тус санхүүжүүлнэ.

4.2.Олон улсын байгууллага, төрийн зарим байгууллагын төсөвт тусган авдаг эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин, биобэлдмэлийн санхүүжилтийн эх үүсвэрийг энэ журмын 4.4-т заасан тусгай дансанд төвлөрүүлэн нэг эх үүсвэрээс худалдан авалт хийж болно.

4.3.Олон улсын байгууллага, гадаад улсын үйлдвэрлэгчээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад шаардагдах урьдчилгаа төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1, 9.3, 11.3-т заасныг үндэслэн шийдвэрлэнэ.



4.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.9-д заасан төлбөрийг гүйцэтгэх төрийн сангийн тусгай данстай байна.

4.5.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.3-т заасан урьдчилгаа төлбөрийг эрүүл мэндийн байгууллагуудад олгох тухайн сарын нэхэмжлэлийн төлбөрөөс суутгаж эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг нөхөн бүрдүүлнэ.

4.6.Ханган нийлүүлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллага, эмийн санд захиалгын дагуу нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, төрөл, тоо хэмжээг санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажуулж эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараа сарын 05-ны өдрийн дотор багтаан хүргүүлнэ.

4.7.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.6-д заасан баримтыг нэгтгэн тухайн сарын 10-ны өдрийн дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.8.Эрүүл мэндийн байгууллагууд нэг эх үүсвэрээс худалдан авч нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийг энэ журмын 4.4-т заасан дансанд тогтоосон хугацаанд шилжүүлэх бөгөөд төлбөр төлөлтийн байдалд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн сан хяналт тавина.

4.9.Гэрээ байгуулсан олон улсын байгууллага, гадаад улсын үйлдвэрлэгч болон ханган нийлүүлэх байгууллагад төлөх төлбөрийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээний нөхцөлийн дагуу шилжүүлнэ.

4.10.Төрийн сангийн тусгай дансанд төвлөрсөн хөрөнгийг энэ журамд зааснаас бусад зориулалтаар шилжүүлэхийг хориглоно.

Тав.Бусад

5.1.Эм, эмнэлгийн хэрэгслийг нэг эх үүсвэрээс худалдан авах ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага нь худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр ил тод мэдээлнэ.

5.2.Нэг эх үүсвэрээс худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, төрөл, үнийн мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn-ийн цахим каталогт тухай бүр байршуулна.



5.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь харьяа нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, төрөл, тоо хэмжээ, төсвийн тооцоолол, зарцуулалтад хяналт тавина.

5.4. Нэг эх үүсвэрээс худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэглээ, зарцуулалтад эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

5.5. Нэг эх үүсвэрээс худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, тээвэрлэлт, хадгалалт, түгээлтэд эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

5.6. Эм, эмнэлгийн хэрэгслийг нэг эх үүсвэрээс худалдан авах ажиллагаанд мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллага хөндлөнгийн хяналт хийж болно.

5.7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.7-д заасны дагуу гэрээний хувь болон холбогдох баримт бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

5.8. Эрүүл мэндийн байгууллагууд нэг эх үүсвэрээс худалдан авахаар захиалга ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх үүсвэрээс худалдан авахыг хориглоно.

---o0o---



Хүснэгт 1-ийн үргэлжлэл
2024 он - 2025 он - 2026 он - 2027 он

Хүснэгт 1-ийн үргэлжлэл
2024 он - 2025 он - 2026 он - 2027 он

2024 он - 2025 он - 2026 он - 2027 он
Хүснэгт 1-ийн үргэлжлэл
2024 он - 2025 он - 2026 он - 2027 он

2024 он - 2025 он - 2026 он - 2027 он
Хүснэгт 1-ийн үргэлжлэл
2024 он - 2025 он - 2026 он - 2027 он

2024 он - 2025 он - 2026 он - 2027 он
Хүснэгт 1-ийн үргэлжлэл
2024 он - 2025 он - 2026 он - 2027 он

2024 он - 2025 он - 2026 он - 2027 он
Хүснэгт 1-ийн үргэлжлэл
2024 он - 2025 он - 2026 он - 2027 он

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ

У/Б-ТӨСЭГЭЙН ҮЙЛЭГЭЙН ТӨЛӨӨЛӨӨ ГЭРЭГ



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3.5

Индекс: 200003